



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/215

Хэрлэн сум

Аймгийн баруун бүсийн наадмыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Боржигон Ажнай Монголын үндэсний морин уралдаан уяачдын холбооны саналыг үндэслэн аймгийн баруун бүсийн наадмын товыг хавсралтаар баталсугай.


2. Аймгийн баруун бүсийн шилдэг хүлэг наадмыг зохион байгуулж ажиллахыг Боржигон Ажнай Монголын үндэсний морин уралдаан уяачдын холбооны тэргүүн (Б.Бат-өлзий)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт, тавьж мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Д.Батхүү), Мал эмнэлгийн газрын дарга (Л.Анхбаяр)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дугаар сарын 18-ны өдрийн
А/215 захирамжийн хавсралт

“Аймгийн баруун бүсийн шилдэг хүлэг” уралдаан

№	Бүсийн уралдаан зохион байгуулах сум	Огноо	Бүсийн нэр
1	Бор-Өндөр	2022.05.13	Аймгийн баруун бүсийн шилдэг хүлэг